

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 13
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	14 – 49
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	18 – 19
2.	<i>Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан</i>	19 – 23
3.	<i>Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	24 – 25
4.	<i>Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2026.04.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	26 – 30
5.	<i>Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	30 – 36
6.	<i>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл. /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	36 – 39
7.	<i>Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	39 – 40
8.	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	40 – 41
9.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/</i>	41 – 49

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 10-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 44 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан;
Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Ч.Лодойсамбуу, Б.Найдалаа,
Э.Одбаяр, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Б.Жавхлан: “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг Байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Нэр дэвшигч Д.Ариунболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэр дэвшигч Ж.Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэр дэвшигч Д.Даваанямыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Нэр дэвшигч Д.Мөнхзоригийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссан О.Амгаланбаатар, Г.Байгалмаа нарыг, мөн өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Т.Сүхболдыг тус тус үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 9

Бүгд: 21

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д "Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ." гэж заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгаас 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 13

Бүгд: 21

38.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 11

Бүгд: 21

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүнээс 2016 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 11

Бүгд: 21

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 11

Бүгд: 21

47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүнээс 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 13

Бүгд: 21
38.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. /14.13/

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2026.04.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хариулж, тайлбар хийв.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, Ч.Ундрэм нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг хариулж, тайлбар хийв.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 9

Бүгд: 21

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал уг асуудлын анхны хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 12

Бүгд: 21

42.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /14:49/

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан хүсэлтийн дагуу хэлэлцүүлгийг хойшлуулахаар тогтов. /14:53/

Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Б.Жавхлан: “Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул

дээрх санал хураалтуудыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний

тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 10

Бүгд: 22

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг “дэмжсэн” санал нь техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 12

Бүгд: 22

45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 15 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 44 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

32 гишүүнтэй Байнгын хорооноос 17 гишүүд хуралдаандаа оролцож байна. Ирц 53.1 хувьтай байна.

Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Чинбатын Ундрал гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүн, Батын Батбаатар гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Ингээд 18 гишүүн боллоо. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

- **Нэг.** Байнгын хорооны тогтоолын төсөл. Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.
- **Хоёр.** Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн нэр дэвшигчийн сонсголын тайлан.
- **Гурав.** Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

- **Дөрөв.** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 04 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Тав.** Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 39 гишүүн 2025 оны 06 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Зургаа.** Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нарын 4 гишүүн 2026 оны 03 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Долоо.** Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 15 гишүүн 2025 оны 11 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Найм.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин 2025 оны 12 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Ес.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2026 оны 05 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Арав.** Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Арван нэг.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Арван хоёр.** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

- **Арван гурав.**Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг нарын 70 гишүүн 2026 оны 05 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Арван дөрөв.**Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга”-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл. Засгийн газрын 2026 оны 05 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Арван тав.**Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 19 гишүүн 2026 оны 05 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.
- **Арван зургаа.**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан. Анхны хэлэлцүүлэг.
- **Арван долоо.**Байнгын хорооны тогтоолын төсөл. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. П.Сайнзориг гишүүний микрофоныг нээе.

П.Сайнзориг: Дарга аа, хэлэлцэх асуудлын 6 дээр байгаа Хот, тосгоны эрх зүйн байдал, хот байгуулах тогтоолтой холбоотой асуудал дээр ажлын хэсэг гаргамаар байна.

Шууд автоматаар яаралтай горимоор гээд. Энэ хууль угаасаа хэрэгждэгээ хэрэгжсэн. Энэ хуулийг дагаж мөрдөх журмын хууль болоод тэр хот байгуулах тогтоол дээр нь өөрчлөлт оруулахад одоо тийм цаг хугацааны хайчинд ороод байгаа зүйл ерөөсөө байхгүй.

Энэ Багануур, Налайхыг хот болгохыг дэмжиж байна. Ингээд туршаад яваад үзье.

Дээрээс нь, Н.Наранбаатар гишүүн бас хэлсэн шүү дээ.

Өмнөговийн зарим сумдыг бас хот болгомоор байна. Үүнийгээ хүлээгээд байна гээд яриад байгаа. Энэ боомтууд чинь хот болж байж л боомтууд чинь хөгжинө өө. Дарга аа. Баг ч юм шиг, сум ч юм шиг ерөөсөө ийм ойлгомжгүй байгаад байхаар хөрөнгө оруулалтаа татаж чадахгүй, хот төлөвлөлтийн асуудлуудаа шийдэж чадахгүй байж байна.

Дээрээс нь, нийслэлийн дагуул хотууд байна. Төлөвлөлтүүд нь хийгээд улсын төсвөөр хөрөнгө оруулалт хийгээд явж байна.

Өөрөөр хэлэх юм бол Хүннү хот байна, Агросити хот байна. Дээрээс нь Эмээлт аж үйлдвэрийн паркийг дагаад бас ийм суурин үүсэх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм зүйлүүдийг нь үлдээгээд, бусад зүйлүүдийг нь хүчингүй болгоод явж болж байгаа байхгүй юу. Дарга аа.

Тэгэхээр би нэгэнт энэ дээр мэргэжлийн Байнгын хорооны ажлын албанаас хариулж өгөөч. Цаг хугацааны хайч алга дарга. Аль хэдийн хууль үйлчилдэгээ үйлчилсэн. Дагаж мөрдөх журмын зохицуулалт болоод хот байгуулах тогтоол дээр угаасаа зарим хотуудыг л хүчингүй болгож байгаа юм чинь үүнийгээ нэг ажлын хэсэг гаргаад ирэх долоо хоногт анхны хэлэлцүүлгийг нь хийгээд явчхаж болдоггүй юм уу?

Тэгээд энэ Агросити, Хүннү хот, Эмээлт аж үйлдвэрийн парк, тэр Өмнөговийн зарим сумуудыг. Дээрээс нь боомтууд байна шүү дээ. Замын-Үүд чинь хот болчихмоор л байгаа юм, уг нь.

Тэгээд ингэж байж л энэ Замын-Үүд боомт чинь бас нэг жоохон өөр болно доо. Үүнийг та Байнгын хорооны даргын хувьд анхаараад, Байнгын хорооны гишүүд маань дэмжээд энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулаад ажлын хэсэг аль аль намаасаа 5 хүн л гаргачихмаар байна. 5 хүн гаргаад л яриад шийдчихэж болдоггүй юм уу? Н.Наранбаатар дарга ч гэсэн адилхан саналтай байгаа болов уу л гэж би бодож байна.

Тийм учраас үүнийг Байнгын хорооны гишүүд маань дэмжиж өгөөд хэлэлцэх асуудлаас хасаад энэ асуудлыг шийдэж өгнө үү.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүн саяын асуудал чинь эсвэл санаачилсан гишүүд нь, эсвэл Байнгын хорооны гишүүд горимын санал гаргаж байж хойшлуулах л үндэслэл үүссэн дээ.

Байнгын хорооны гишүүд болон хууль санаачлагчаас тийм санал горим байгаа юм уу? 15 дугаар асуудал явлаа шүү дээ.

Саяынх дээр тэгээд санал байхгүй бол үүгээр явлаа шүү. Санал байхгүй байна шүү. П.Сайнзориг гишүүн ээ. 15 дээр ч гэсэн Үндэсний их баяр наадам дээр хууль санаачлагчаас санал гарсангүй шүү.

Хэлэлцэх асуудалдаа оръё. /алх цохив/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Нэг.Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдад санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийг сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1 дэх заалтад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсголыг хийхээр тус тус заасан.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга гишүүн Пүрэвээгийн Дэлгэрнарангийн өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 115 дугаар тогтоолоор Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн.

Төрийн байгуулалтын байнгын хороонд санал болгосон Барсүрэнгийн Баасандоржийн бүрэн эрхийн хугацаа мөн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болсон тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулна.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төсөл.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн

30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн нэр дэвшигч Цэцэгмаагийн Уртнасан, Нэргүйн Мягмар нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхланг сонгосугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай гэжээ.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 19 гишүүн оролцож, 13 гишүүн зөвшөөрч, санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хоёр.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж эхэлье.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг танилцуулна.

Нэр дэвшигч Дашживаагийн Ариунболд, Жамсранжавын Болд, Довдонгийн Давааням, Доржсүрэнгийн Мөнхзориг нарын танилцуулгыг Та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хуралд нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1 дэх заалтад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсголыг хийхээр тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд заасан нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан дараах шатлан дараах ажиллагааг явууллаа.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дашживаагийн Ариунболд, Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Жамсранжавын Болд, Довдонгийн Давааням, Улсын Дээд шүүхээс нэр дэвшүүлсэн Доржсүрэнгийн Мөнхзориг нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

2.2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 31.1 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” тогтоолыг баталж, 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан томилсон.

3.Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан.

Сонсголын тов, хугацаа сонсголд оролцогчдыг бэлтгэх хуудас бүхий зарыг Улсын Их Хурлын цахим хуудсанд 14 хоногийн хугацаанд байршуулсан.

Мэдээллийн дагуу 3 оролцогч, 2 ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хорооны хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж баталгаажууллаа.

4.2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 14.00 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, С.Бямбацогт, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, С.Зулбагар, Б.Найдалаа, Б.Пүрэвдорж, Ч.Ундрал, Н.Учрал, Б.Хэрлэн, О.Цогтгэрэл, Б.Энхбаяр нар буюу Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын 2 өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гарна.

Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана гэж, 133.3 дахь хэсэгт сонсголын тайланг нийтлэхээс ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө нэр дэвшигч болон түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлнэ гэж тус тус заасны дагуу 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Дашживаагийн Ариунболд, Жамсранжавын Болд, Довдонгийн Давааням, Доржсүрэнгийн Мөнхзориг нарыг ажлын хэсгийн тайлан ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд хуралдаанд оролцсон гишүүдэд санал нэгтгэйгээрээ дэмжлээ.

Монгол Улсын Их Хурал Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нь нэрээ өгнө үү. А.Ариунзаяа гишүүнээр тасаллаа. /алх цохив/

А.Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Би сонсголд бүрэн оролцож нэр дэвшигчдээс асуулт асуусан.

Анхаарал хандуулах зайлшгүй нэг асуудал байгааг Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдэд хэлсэн нь зүйтэй байх гэж бодож байна.

Төрийн байгууллагуудын зөвлөлийн орон тооны бус гишүүнд хэд хэдэн байгууллагад бид хүмүүсийг Улсын Их Хурлаас томилж явуулдаг.

Ингэхдээ уг нь тухайн албан тушаалаар нь энэ байгууллагуудын үйл ажиллагаанд нь төрийн байгууллагуудын хоорондын хяналт болон чиг үүргүүдээ сайн зохицуулах үүднээс албан тушаалаар нь уг нь явуулдаг байхгүй юу.

Сонгуулийн ерөнхий хороо нь жишээлбэл Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга маш чухал үүргийг гүйцэтгэдэг.

Эдгээр хүмүүс нь хүнийхээ нэрээр сонгогдоод Улсын Их Хурлаас томилолт авахаар эргээд хууль дээр орон тоо, албан тушаалаар нь гэж байхгүй байгаа учраас тухайн хүн нь албан тушаалаасаа буулаа гэхэд чөлөөлөгдөх үндэслэл байхгүй болоод байдаг.

Өмнө нь жишээлбэл Сонгуулийн ерөнхий хороонд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаасаа буусан хүн өгөхгүй хэвээрээ одоо энэ орон тооны бус гишүүнээрээ яваад, албаны унаа тэрэг хүртэл ашиглаад.

Гэтэл жинхэнэ ажлаа хийх ёстой, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах ёстой хүн нь орж чадахгүй ийм нөхцөл байдал үүссэн юм.

Тэгэхээр цаашлаад хуулиудыг өөрчилж Монголбанкны орон тооны бус гишүүнийг ч гэсэн томилоход Сангийн яамнаас яг тодорхой энэ асуудлыг мэдэж байгаа газрын даргаа томилуулахаар санал болгоод оруулж ирж байхад тухайн хүнийг нь шүүмжилсээр байгаад буцаасан ийм тохиолдол ч гэсэн гарсан.

Тийм учраас цаашид албан тушаалаар нь хуульчилж өгөхгүй бол хүн солигдсонтой холбоотой их хүндрэл учирч байна шүү гэдгийг онцолж энэ протоколд үлдээх гэсэн юм. Тийм.

Албан тушаалаасаа буух юм бол өөрсдөө саналаараа хүсэлтээ гаргаж чөлөөлөгдөх ёстой шүү гэдгийг онцолж хэлье.

Б.Жавхлан: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.2 дахь хэсэгт гишүүд нууц санал хураалт явуулахаар заасан байгаа.

Иймд Байнгын хороон дээр мөн нууц санал хураалтыг цахимаар явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэж, техникийн албаныхан горимд шилжүүлнэ үү.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Төхөөрөмжөө идэвхжүүлнэ үү. Санал хураалт.

1.Нэр дэвшигч Дашживаагийн Ариунболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

2.Нэр дэвшигч Жамсранжавын Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

3.Нэр дэвшигч Довдонгийн Даваанямыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

4.Нэр дэвшигч Доржсүрэнгийн Мөнхзоригийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, уг санал 61.9 хувиар дэмжигдлээ.

Нэр дэвшигчид дэмжигдсэнтэй холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дууссан Одонмажигийн Амгаланбаатар, Гочоосүрэнгийн Байгалмаа нарыг, мөн өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Төмөрбаатарын Сүхболдыг тус тус үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 57.1 хувиар уг санал дэмжигдлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хур Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга 2026 оны 05 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, санал 38.1 хувиар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа нарын 46 гишүүн 2026 оны 05 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, санал 61.9 хувиар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 06 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, уг санал 47.6 хувиар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 8 гишүүн 2016 оны 06 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, уг санал 47.6 хувиар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 06 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, уг санал 47.6 хувиар дэмжигдсэнгүй.

Та нар энэ саяын санал хураалтынхаа дүнг хар даа. Та нар намын даргынхаа саналыг танайх өөрсдөө унагаасан байна шүү. Эндээс хэдэн дэмжсэн, хэд нь дэмжээгүйг өөрсдөө хар даа. Тийм.

Б.Батбаатар, Л.Гантөмөр, Ө.Шижир гишүүд өөрсдөө дэмжээгүй байна шүү.

6.Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, уг санал 38.1 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын
хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан
2026.04.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Дөрөв.Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 04 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна.

Ж.Алдаржавхлан гишүүний микрофоныг нээж өгье.

Ж.Алдаржавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй бөгөөд парламентын нээлттэй сонсгол бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх өндөр ач холбогдолтой олон нийтийн оролцоотой механизм болдог билээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай зэрэг хуулийн хүрээнд 2020 оноос хойш Монгол Улсын Их Хурлаас нүүрсний тээвэрлэлт, Хөгжлийн банкны, агаарын бохирдлыг бууруулах, ковид 19 цар тахлын үеийн төсвийн зарцуулалт зэрэг 6 ерөнхий хяналтын сонсгол, хүүхэд, багачуудын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрх, эрхийн хэрэгжилтийн талаар зэрэг 4 хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол, нэр дэвшигчийн сонсгол 34 удаа, нийт 44 сонсголыг зохион байгуулсан байна.

Энэ хугацаанд төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулагдаагүй байна.

Парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий хэдий ч сонсголын үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцон шалгах, үр дүнгийн сонсголыг зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Иймд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн

сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлага харгалзан үзэж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг тодруулсан хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлох бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлэг буюу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол, түүний төрөл зохион байгуулахтай холбоотой 26 дугаар зүйлд нэмэлт оруулахаар өргөн барьж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Батын Батбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Батбаатар: Одоогийн хуульд –

- хүний эрхийн хяналтын сонсгол,
- төсвийн хяналтын сонсгол,
- ерөнхий хяналтыг сонсгол,
- нэр дэвшигчийн сонсгол гэсэн 4 төрөлтэй байна.

Тэгээд “үр дүнгийн сонсгол” гэдэг одоо 26.1 дээрээ байхгүй байгаа.

- ▷ **Нэгдүгээрт**, үр дүнгийн сонсгол гэж яг юу болохыг бүрэн тодорхойлоогүй байна гэж хараад байгаа юм.
- ▷ **Хоёрдугаарт нь**, зүгээр “зохион байгуулж болно” гэдэг нь хэтэрхий сул заалт буюу нөгөө хүсээд байгаа хуулийнхаа өөрчлөлттэйгөө зөв юм уу, буруу юм уу гэдэг.
- ▷ **Гуравдугаарт нь**, одоогийн хуулийн 10 дугаар зүйлтэй давхцаад байгаа юм биш үү. 10.2, 10.3 дээрээ тайланг ирүүлэх Байнгын хороо хэлэлцэх журмыг заасан байна гэдэгтэй.

Хэрвээ “үр дүнгийн сонсгол” гэдэг нь шинэ төрөл юм бол 26.1 дээрээ нэмэхгүй юм уу?

Чуулганы дэгийн тухай хуулийн 119.6-д нэг асуудлаар нэг жилийн дотор дахин хяналтын сонсгол хийхгүй гэж заасан. Тэгвэл –

- Үр дүнгийн сонсголыг анхны сонсгол хийснээс хойш ямар хугацааны дараа хийх юм бэ?
- Нэг жилийн хориг нь адилхан үйлчлэх юм уу?

Түрүүн асуусан “зохион байгуулж болно” гэдэг нь эрх олгосон боловч үүрэг үүсгээгүй байна гэж үзэж байна.

- Үүрэг нь үүсгэгдээгүй тохиолдолд энэ чинь тийм зөв байж чадах юм уу?
- Байнгын хорооны үзэмжээр шийдэгдээд явдаг болох юм уу?
- Үр дүнгийн сонсгол хийх босго шалгуур нь юу байх юм бэ?

Өгсөн чиглэлийнхээ нөгөө 50 хувиас дээш, доош яригдсан тайлан ирсэн, ирээгүй, нийтийн өргөдөл, гомдол байгаа эсэх гээд.

Тэгээд зардлынхаа тооцоонд улсын төсвөөс хөрөнгө шаардахгүй гэсэн байна.

Гэхдээ энэ сонсгол чинь нөгөө зохион байгуулах танхим, оролцогч, шинжээч гээд, бичиг хэрэг, орчуулга, цахим дамжуулалт гээд тодорхой хэмжээний зардалтай.

- Энэ зардлаа тооцсон юм уу?

- Үр дүнгийнхээ сонсголыг зөвхөн хяналтын сонсголдоо хамааруулах юм уу, эсвэл нөгөө төсвийн сонсгол, хүний эрх, ерөнхий хяналт, нэр дэвшигчийнхээ сонсголд бүгдэд нь хамааруулж ойлгох юм уу?

Жишээлэх юм бол “нэр дэвшигчийн сонсгол” дээр “үр дүнгийн сонсгол” хийх нь хэр зохимжтой байж болох юм.

Тэгээд энэ төсөл маань хэрвээ батлагдвал Их Хурлын хяналтын чанар сайжрах яг тийм бодит үзүүлэлт нь юу байх юм? Зүгээр ийм процесс нэмсэн асуудал болж байна уу гэдэг ийм зүйлүүдийг асууж байна.

Б.Жавхлан: Ж.Алдаржавхлан гишүүн. Хууль санаачлагч. Микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: Б.Батбаатар гишүүн олон чухал асуудлыг хөндлөө.

Ер нь Монгол Улсын Их Хурлаас олон сонсгол зохион байгуулдаг. Маш олон сонсголыг зохион байгуулдаг. Тэгээд эргээд үр дүн нь ерөөсөө тодорхойгүй байдаг. Одоо жишээ нь “нүүрсний сонсгол”, “ногоон автобусны сонсгол”. Олон сонсгол зохион болоод яг хэн ямар хариуцлага хүлээсэн нь огт тодорхойгүй үлддэг учраас зайлшгүй нэг жилийн дараа үр дүнг нь сонсож энэ сонсголоор бий болсон нөхцөл байдлыг үнэлж дүгнээд нөхдүүд ямар хариуцлага хүлээсэн бэ

гэдгийг ил тод ард иргэдэд зарлах нь зүйтэй гэж үзэж миний би одоо энэ заалтыг оруулсан юм.

Зөвхөн хяналтын сонсголын чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна гэж үзэж байгаа.

Б.Батбаатар гишүүний саналууд байна. Зохион байгуулж болно гэдэг чинь сулдчихаж байгаа юм байна шүү гэж байна. Үүнийг хэлэлцүүлгийн явцад засаад явчхаж болох байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Болсон уу? Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Байнгын хорооны гишүүд, хууль санаачлагч гишүүд өөрсдөө орж ирж байж байгаад энэ чинь асууж тодруулах юмнууд зөндөө гарч байна гишүүдээс.

Тийм учраас санаачилсан хуулиуд дээрээ өөрсдөө идэвхтэй, хариуцлагатай байж энэ хуулиудаа авч гарна шүү. Өөрсдөө байхгүй. Тэгээд танилцуулсан зүйл ч байхгүй. Гишүүдтэйгээ ойлголцоогүй ийм байж байгаад тэр хойгуур нь тэгээд хуулиуд нь унасны дараа бол одоо тэгээд ярих юм байхгүй шүү дээ.

Санал хураалт явлаа шүү. Гишүүд ирцэд хүрч байна. Л.Мөнхбаатар дарга. Таных ороогүй байна уу? Үгүй ээ, ороогүй байна.

Санал хураалтад бэлтгэл хангагдлаа. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, уг санал 52.4 хувиар дэмжигдлээ.

Жудагийн Баярмаа гишүүнийг дэмжсэнээр авна уу.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалд оръё.

**Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн
2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Тав.Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг нарын 70 гишүүн 2026 оны 05 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна.

М.Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Эдийн засгийн байнгын хорооны доор Эрчим хүчний хөгжлийн дэд хороо байгуулъя гэсэн ийм хууль санаачилсан байгаа.

Тэгээд энэ дэд хороог байгуулах нь зүйтэй юм гээд 70 гишүүн дэмжиж гарын үсэг зурсан.

Ерөнхийдөө дараах үндэслэлээр Эрчим хүчний дэд хороо байгуулах нь зүйтэй юм байна гэж үзсэн байгаа.

Нэгдүгээр асуудал нь Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын тухай хуулийн 23.1-д зааснаар нийтдээ 30 асуудлыг хариуцдаг юм байна.

Эдийн засаг, улсын төлөвлөгөө, Монголбанк, стандарт, эрчим хүч гээд 30 асуудлыг. Өөрөөр хэлбэл Эдийн засгийн байнгын хороо хэт олон асуудлуудыг хариуцдаг учраас тэргүүлэх салбарууд маань ерөнхийдөө хаягдаад байна. Тэргүүлэх салбарт Улсын Их Хурлын гишүүд хувь нэмрээ оруулж ажиллах боломж нь жаахан хязгаарлагдмал байна гэж үзсэн.

Тэгээд Эрчим хүчний хөгжлийн дэд хороотой болсноороо эрчим хүчний салбарт буюу тулгамдаж байгаа олон асуудлуудыг шийдвэрлэхд Улсын Их Хурлын гишүүдийн оролцоо хангагдана гэсэн ийм үзэл баримтлалтай байгаа.

Дээрээс нь Эрчим хүчний хөгжлийн дэд хороог байгуулснаараа ямар нэгэн төсөв мөнгө, бүтэц ч гэдэг юм уу шинээр гарч ирэхгүй тийм бүтэц байгаа.

Ерөнхийдөө эрчим хүчний чиглэлд нэлээн түлхүү анхаарал хандуулж ажилладаг 4, 5 гишүүд орж ажиллаад, тэгээд маш идэвхтэй эрчим хүчний салбарт тулгамдаж байгаа асуудлыг сонсьё, мөн энэ асуудлуудыг шийдэхийн төлөө, бас Улсын Их Хурлын тогтоолыг батлуулахын төлөө салбарын сайд, мөн салбарын мэргэжилтнүүдтэй нягт хамтарч ажиллая гэсэн ийм үндэслэлээр үүнийг гаргасан байгаа.

Тийм ч учраас яалт ч байхгүй эрчим хүчний салбар маань нэлээн тулгамдсан салбар. Олон асуудлууд байна. Бид өвөлд хэрэглэгчээ яаж дулаан, цахилгаанаар нэг хөлдөөчихгүй шиг өвлийг давах вэ гэдэг олон асуудал байна.

Энэ салбарын стандарт аюулгүй ажиллагаа, хүний нөөцийг бэлдэх, ажиллагсдын цалинг нэмэхтэй холбоотой гээд үй түмэн асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ асуудлууд мэдээж гишүүд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулж ажиллах шаардлагатай байгаа.

Тэгэхээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд ажиглаад байхад Эдийн засгийн байнгын хороо хэт олон асуудлыг хариуцдаг учраас үнэхээр тэргүүлэх салбарууд хаягдаад байна, орхигдоод байна гэж үзсэн учраас Эрчим хүчний дэд хороо байгуулъя гэсэн санал санаачилга гаргаж хууль өргөн барьж байгаа юм.

Тийм учраас Байнгын хорооны гишүүд маань дэмжээд өгөөрэй гэж хүсье.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Батын Батбаатар гишүүнээр тасаллаа. Ч.Ундрэм гишүүнийг нэмж оруулъя. Ч.Ундрэм гишүүнээр тасаллаа.

Батын Батбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Батбаатар: Эрчим хүчний дэд хороо гэдгийг уг нь дэмжиж байгаа юм.

Төсөл санаачлагч байж байгаад нэрээ татаж авсан. Их Хурлын тухай хуулийг хэлэлцэх ажлын хэсэгт оролцох шаардлага байсан учраас нэрээ татаад авсан юм.

Тэгэхдээ Эрчим хүчний дэд хороо гэдэг нэр өөрөө эмчилгээ болохгүй. Хуулийн 27.3.7-д “эрчим хүчний хөгжлийн” гээд нэмсэн байгаа.

Тэгэхдээ 27.5-д энэ дэд хороо яг ямар асуудал эрхлэхээ нарийвчлан тусгаж чадаагүй байгаа. Нэг ёсондоо нэр нь байдаг. Чиг үүрэг буюу нөгөө хэмжих үзүүлэлт, хэрэгжүүлэх тэр чиг үүргүүдийг нь 27.5-д нэмж оруулах талаар бодсон зүйл байгаа юу гэж асуумаар байгаа юм.

Дээрээс нь, эрчим хүчний асуудал гэдэг нь дэд хороо жилд нэг удаа биш улирал тутам Засгийн газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, холбогдох төрийн өмчит компани дундын тайланг сонсдог байх ёстой. Одоо орж байгаа төслөөр жилд нэг удаа гээд явж байна гэж үзээд байна.

Тэгэхээр үүн дээр хууль санаачлагч ямар бодолтой байгаа юм. Санхүүгийн асуудлууд. Хэмжих 5 гол үзүүлэлт байна гэж хараад байгаа шүү дээ. Хуульд.

- ➔ Импорт;
- ➔ оргил ачааллын нөөц чадал;
- ➔ шинэ эх үүсвэр;
- ➔ сүлжээний алдагдал;
- ➔ салбарын санхүүгийн алдагдал гэсэн энэ 5 асуудал яаж тусгах юм?

Тэгээд энэ дэд хороо нь зөвхөн сайхан сонсгол хийгээд байдаг байж болохгүй. Томоохон төслүүд дээр –

- хугацаа,
- хариуцах байгууллага,
- санхүүжилт,
- дараагийн алхмыг ил тод мэдээлдэг –

-парламентын хяналтын самбар болж энэ дэд хороо ажиллах ёстой гэж бодож байна.

Тарифын шинэчлэл, хөрөнгө оруулалт, төрийн өмчийн компаниудынхаа өр төлбөр алдагдлыг хэлэлцэхээсээ зайлсхийвэл энэ дэд хороо зүгээр реформын гэдэг шинж чанараа алдна.

Тэгэхээр үүнийг зүгээр нэг улс төрийн тайвшруулах бүтэц буюу олон нийтэд эрчим хүчтэй холбоотой асуудал байна. Түүнд хамарсан дэд хороо байгуулж байгаа юм байна. Асуудал шийдэж байгаа юм байна гэдэг ийм нэр орж болохгүй.

- Чиг үүргүүдийг нь,
- хэрэгжүүлэх ажлуудыг нь,
- хариуцах, тайлагнах олон олон болохгүй байгаа зүйлийг гаргаж ирдэг.

Энэ зүйлүүдийг нь гаргаж ирээд, тэгээд тэр эрх мэдэл, хариуцлагаа тооцоо хяналттай нь хамтатгаж явахгүй бол одоо байгаа төслөөрөө зөвхөн нэр нэмээд. Зөвхөн нэр нэмсэн гэж хараахан хэлж болохгүй байх.

Гэхдээ жаахан дутагдалтай байна гэж хараад байгаа юм.

Тэгээд дэд хороо улирал бүр түрүүн ярьж байсан 5 үзүүлэлтээр Засгийн газрын тайланг сонсдог байх. Эрчим хүч бол Монголын хөгжлийн үндэс суурь. Нөгөө хүнд үйлдвэр, хөдөө аж ахуй, дулаан тухтай амьдрал энэ бүх асуудлыг шийдэх эх үүсвэр.

Өнөөдөр бид чадлын дутагдлаа нөхөх тухай харж байгаа болохоос биш хөгжлийн төлөө илүү ямар нэмэлт эрчим хүч хийдэг вэ гэдгээ ерөөсөө бодохгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэлүүдээр хууль санаачлагчийнхаа хувьд ямар оруулах зүйлүүд дээр анхаарч болж байна... /минут дуусав/

Б.Жавхлан: Хууль санаачлагч М.Энхцэцэг гишүүний микрофоныг нээе. Хариулт.

М.Энхцэцэг: Б.Батбаатар гишүүндээ баярлалаа. Маш сайхан санаачилгууд, нэмэлт саналуудыг хэлж байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн ажлын хэсэгтэй нэгтгэгдээд явах учраас таны саяын хэлсэн нэлээн детальчилсан үүрэг ролийн заах юмнуудыг нэмэлт оруулаад явах бүрэн боломжтой.

Таны хэлж байгаа зүйтэй. Эрчим хүчний салбарт таны хэлсэн 5 чиглэлээр салбарын сонсгол тайланг хийх, энэ чиглэлээр Улсын Их Хурлын тогтоол батлах, энэ чиглэлээр Улсын Их Хурлын гишүүд юу хийж болох боломжтой бүх зүйлүүдийг хийхийн төлөө ажиллах юм.

Ер нь Улсын Их Хурлын тухай хуульд дэд хорооны үүрэг, харилцаа хязгаарлагдмал байдаг юм билээ.

- Мэдээлэл сонсох.
- Санал, дүгнэлт гаргах.
- Шаардлагатай бол Улсын Их Хурлын тогтоолын төсөл гаргах.

Гэх мэтчилнээр байдаг юм билээ.

Гэхдээ нэгэнт бид Улсын Их Хурлынхаа хуулийг шинэчилж байгаа тохиолдолд таны хэлснээр юуг хийх юм, яаж хэмжих юм, ямар хугацаанд хуралдах юм гэдгээ нэлээн нарийвчилсан байдлаар тусгаад явах бүрэн боломжтой байгаа.

Тэгээд таны хэлж байгаа зүйтэй. Дэд хороог байгуулснаараа Улсын Их Хурал дээрх нээлттэй платформ, хяналтын самбар болж ажиллах гээд бас их гоё үг хэлж байна.

Тэгэхээр энэ чиглэл рүү хууль дээр тусгаад явъя гэж бодож байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Чинбатын Ундрэм гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Ч.Ундрэм: Энэ асуудлыг ер нь дэмжиж байгаа.

Бид 2024 онд Улсын Их Хурлын тухай хуулийг өөрчлөхдөө хэтэрхий нүсэр том ийм цөөхөн Байнгын хороодыг байгуулсан.

Тэгээд асуудлаа бараг хэлэлцэж бардаггүй, амждаггүй. Мэргэжлийн гэдэг агуулга нь зарим талаараа алдагдаад байгаа.

Тийм учраас Байнгын хороодыг буцаагаад жоохон нэмээд мэргэжлийн гэдэг тэр агуулга руу нь илүү оруулах нь зөв гэж би үзэж байгаа юм.

Тэгээд жишээлбэл Эдийн засгийн байнгын хороо бүхэлдээ –

- Монголын банк санхүүгийн тогтолцоо,
- Монголбанк,
- арилжааны банк,
- Санхүүгийн зохицуулах хороо,
- Үндэсний статистикийн хороо гээд энэ бүх банк, санхүүгийн тогтолцоо.

Түүнээс гадна маш том том салбаруудыг хэлэлцээд байгаа юм.

- Агаарын тээвэр,
- төмөр зам,
- эрчим хүч гээд юу юу байдаг юм. Тийм ээ.

Бүр арай дэндүү өргөн хүрээг хамараад.

Тийм учраас үүнийг жоохон зөв чиг үүргийн дагуу болгох шаардлагатай гэж үзээд байгаа юм.

Гэхдээ М.Энхцэцэг гишүүн ээ, Та Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тэнд зарчмын зөрүүтэй саналаа өгч хураалгаад, тэр ажлын хэсэг дээр шууд явбал илүү хурдан юм биш үү? Ингэж тусад нь хэлэлцүүлэх ямар хэрэгцээ шаардлага байгаа юм бэ?

Энэ дээр л гайхаад байна. Яг одоо ажлын хэсэг давхар зэрэгцээд яваад байгаа байхгүй юу.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн М.Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

М.Энхцэцэг: Ч.Ундрам гишүүндээ баярлалаа. Хэлж байгаа асуудлууд нь зүйтэй.

Яагаад гэхээр бид цаашдаа ер нь аль болох мэргэжлийн, ялангуяа Улсын Их Хуралд мэргэжлийн гишүүд их орж ирсэн учраас мэргэжлийн чиглэл рүү дэд хороотой болоод, үйл ажиллагаагаа нэлээн нарийвчилсан байдлаар зохион байгуулж явах нь нэлээн үр дүнтэй байгаа гэж харж байгаа.

Тийм ч учраас 70 гишүүн маш зүйтэй асуудал гээд дэмжсэн байх гэж бодож байгаа.

Тийм ээ. Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэхтэй холбоотой ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Би зэрэгцүүлээд энэ хоёр хуулийг нэгтгээд хэлэлцээд явах байх гэдэг үүднээс хууль өргөн барьсан.

Тэгээд дэмжээд явах юм бол тэр хуультай нэгтгэгдээд ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд явах байх гэж бодож байгаа. Бусдаар яг тэр хууль дээр бас зарчмын зөрүүтэй санал уг нь гаргасан юм.

Тэгэхдээ Улсын Их Хурлын дарга болон бусад хүмүүстэй зөвлөлдөхөөр яах вэ, нэгэнт ингээд 76 гишүүн гарын үсэг зурсан тусдаа хууль явсан учраас Төрийн байгуулалтаараа хэлэлцүүлээд цаашаа явах нь зүйтэй гэсэн байгаа.

Б.Жавхлан: Тийм. Нэгтгэх асуудал цаг хугацааны хувьд өнгөрсөн шүү дээ. М.Энхцэцэг гишүүн ээ.

Уг нь Ч.Ундрам гишүүний хэлж байгаа санаа бол зөв л санаа хэлээд байна даа. Анхнаас нь уг нь тийшээгээ оруулаад явуулахгүй дээ.

Болсон уу? Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлэн боллоо. Санал хураалт.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжигдэж, уг санал 57.1 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Зургаа.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
/Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл
/Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Зургаа.Засгийн газрын 2025 оны 05 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Пүрэвийн Зоригтбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга.

Ажлын хэсгийг оруулъя. Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга.

Ажлын хэсгээс 5 төрийн албан хаагч байх ёстой. Ганцхан Анандын Энхманлай дарга байна. А.Энхманлай дарга ажилдаа маш хариуцлагатай хандаж, хуралдаа идэвхтэй оролцож байгаа юм байна. Бусад нь байдаггүй.

Байхгүй дарга нарыг нь зарлана. Энэ Пүрэвийн Зоригтбаатар гэж нөхөр байхгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга хийдэг хүн байна. Баттулгын Бямба гэж нөхөр бас байхгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Доржийн Энхтөр гэж нөхөр бас байхгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга. Нацагийн Хонгорзул дарга бас байхгүй. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын ахлах референт гэж байна шүү.

Ийм олон дарга нар байхгүй байна.

Жигжидийн Батжаргал гишүүн горимын санал гаргая. Микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Анх энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж батлуулсан Их Хурлын гишүүдээс ч асуудал гарч ирээд байгаа юм. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг явуулах гэхээр зэрэг ажлын хэсэг байхгүй байгаа учраас энэ хуулийг хойшлуулъя.

Тэгээд энэ хугацаанд нь тэр анх хууль батлуулсан гишүүдтэй ч санал онолоо нэг ярилцаад нэгдсэн ойлголтод хүрээдэхье.

Б.Жавхлан: Зөв байх аа. Хуулийн зөрчил үүсээд байгаа асуудал дээр өнөөдөр тов нь зарлагдаад хэлэлцэх асуудалдаа орсон явж байхад энэ төрийн албан хаагч нараас бүрдсэн ажлын хэсэг бүрэлдэхүүнгүй байна гэдэг маш хариуцлагагүй байна шүү.

Энэ парламент чуулган, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд ингэж үл хүндэтгэсэн байдлаар хандаж огт болохгүй. Бараг анх удаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн байхгүй шалтгаанаар гишүүн горимын санал гаргаж санал хураалгах гэж байна шүү.

Жигжидийн Батжаргал гишүүний гаргасан саналаар уг асуудлыг хойшлуулъя гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Жигжидийн Батжаргал гишүүн горимын санал гаргасан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байхгүй учраас уг хэлэлцүүлэх асуудлыг хойшлуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 42.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тэгэхээр уг асуудлыг хэлэлцэх нь. Нөгөө ажлын хэсгийн бүрэлдэхүүн байдаггүй. 5 ажлын хэсгийн бүрэлдэхүүн байх ёстой. 2 гишүүн.

Аюушийн Ариунзаяа гишүүн горимын санал гаргая гэж байна. Микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Энэ санал хураалтыг хүчингүй болгоод, дахиад санал хурааа даа. Хойшлуулах нь ер нь зүйтэй байх.

Тэгээд ер нь Засгийн газрын бүхэл бүтэн Хэрэг эрхлэхийн сайд байхад Засгийн газрынхаа өргөн мэдүүлсэн асуудлыг өөрөө аваад гарах хэрэгтэй шүү дээ. Тийм л чухал юм бол. Хоёр ч удаа хойшлуулсан асуудал.

Танай Засгийн газар нэг нэг сайдыгаа тэрнийгээ дууд, үүнийгээ дууд гэж болохгүй. Өөрөө Хэрэг эрхлэхийн сайд юм бол өөрөө дууд за юу. Миний дууддаг албан тушаалтан биш. Үүнийг хүчингүй болгож өгөхийг хүсье.

Б.Жавхлан: Аюушийн Ариунзаяа гишүүн горимын санал гаргалаа.

Ажлын хэсгийнхэн болон ажлын албаныхан Засгийн газраас нь асуудлаа оруулж байгаа хариуцсан Шадар сайд нь. Уучлаарай. Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан байх ёстой шүү.

С.Амарсайхан сайд өөрөө байхгүй бол энэ асуудал ингээд хэлэлцэхгүй хойшлогдох нь байна шүү.

Аюушийн Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Засгийн газрын 2025 оны 05 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан өргөн барьсан Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан Төрийн байгуулалтын байнгын хороонд яаралтай ирнэ үү.

Энэ асуудал чинь цаашаа явахгүй нь байна шүү. Ажлын хэсэг нь байхгүй. Өөрөө байхгүй. Гишүүд асуудлыг хойшлуулах горимын санал гаргасан боловч дэмжигдээгүй учраас санал хураалтаа үргэлжлүүлье.

Нэг.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Асуулт, саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Ж.Батжаргал гишүүнээс зарчмын зөрүүтэй саналыг урьдчилж бичгээр ирүүлсэн байна.

Саналын томъёолол. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Ж.Батжаргал гишүүний микрофон өгье. Горимын санал.

Ж.Батжаргал: Энэ асуудал дээр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг ажлын 5 хоногийн завсарлага авъя.

Б.Жавхлан: Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал гишүүн санал гаргасан учраас бүлгээс уг асуудал дээр 5 хоногийн завсарлага авч байна. 5 хоногийн завсарлага. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн
2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 19 гишүүн 2026 оны 05 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Монголын үндэсний харваачдын холбооноос хууль санаачлагч нарт хандаж энэ хуулийн төслийг хэлэлцүүлгийг хойшлуулж өгнө үү гэсэн юм байна лээ.

Ингээд П.Сайнзориг гишүүн нарын хууль санаачлагч нар нь хэлэлцүүлгийг хойшлуулж өгнө үү гэж өөрсдөө санал гаргасан байгаа. Хүсэлт гаргасан байгаа.

Тийм учраас уг саналыг хойшлуулах горимын саналаар санал хураана.

Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү.

Хууль санаачлагч өөрийн хүсэлтээр хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн учраас уг асуудлыг хэлэлцүүлэхийг хойшлууллаа. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Найм.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй
холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Найм.Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар уншиж танилцуулна.

Л.Мөнхбаатар: Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн.

Уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хороо “Ажлын хэсэг байгуулах тухай” 2026 оны 04 дүгээр тогтоол гаргасан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг нэг удаа хуралдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ч.Ундрам нар ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 4 жил байна гэж заасны “4 жил” гэсэн нь Монгол Улс Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгчөөр 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр дүгнэлт гарсан билээ.

Ажлын хэсэг дээрх асуудлыг судлан үзэж хэлэлцээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “4 жил” гэснийг “6 жил” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Жавхлан: Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүд байна уу?

Алга байна. /алх цохив/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулна.

Лхагвын Мөнхбаатар гишүүн горимын саналтай байгаа юм байна. Гишүүний микрофоныг нээж өгье.

Л.Мөнхбаатар: Уг хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаагүй учраас уг хуулийн төслийг эцэслэн батлах үе шаттай хамтатган шийдвэрлэж өгөх горимын санал хураалгаж өгнө үү.

Б.Жавхлан: Л.Мөнхбаатар гишүүний гаргасан горимын саналаар хэлэлцэх шатанд зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас эцэслэн батлах шатанд хамт явуулах горимын санал гаргаж байна.

Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Д.Энхтуяа гишүүн санал хураалтад ороорой. Д.Энхтуяа гишүүн санал хураалтад бэлтгээрэй.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар Л.Мөнхбаатар гишүүний горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулах юм байна шүү.

Дараагийн асуудалдаа оръё.

Ес.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан
авах арга хэмжээний тухай/

Ес.“Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 04 сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажилласан байгаа.

Ажлын хэсгээс бүрэн хэрэгжсэн шийдвэрт заасан хугацаа дууссан. Тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын шийдвэрийг хяналтаас хасах Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

А.Ариунзаяа гишүүний микрофоныг нээж өгье.

А.Ариунзаяа: Тус Байнгын хорооноос 2026 оны 04 сарын 22-ны өдөр надаар ахлуулаад, О.Алтангэрэл, Б.Батбаатар, С.Зулбахар, Ч.Ундрам гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж ажлын хэсэг ажиллаж дууслаа.

Та бүхэнд өнгөрсөн долоо хоногт тогтоолын төсөл болон хяналтаас гаргах заалтуудыг шуудангаар хүргүүлсэн байгаа.

Ажлын хэсэг хуралдаж Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажиллаад шууд хариуцан тайлагнадаг байгууллагад үүрэг чиглэл болгосон Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах 16 хуулийн 71 заалт хяналтад одоо байна.

12 хуулийн 53 заалтыг бүрэн хэрэгжсэн гэж үзэж байгаа учраас хяналтаас хасах.

Улсын Их Хурлын 37 тогтоолын 115 заалт хяналтад байгаа.

Бүрэн хэрэгжсэн үндэслэлээр 20 тогтоолын 41 заалт цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон үндэслэлээр 3 тогтоолын 4 заалт, шийдвэрт заасан хугацаа дууссан үндэслэлээр 1 тогтоолын 1 заалт, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан үндэслэлээр 2 тогтоолын 3 заалт, нийт 26 Улсын Их Хурлын тогтоолын 60 заалтыг тус тус хяналтаас хасахаар оруулж байна.

Байнгын хорооны 11 тогтоолын 74 заалт хяналтад хэвээрээ байгаа.

Бүрэн хэрэгжсэн үндэслэлээр 7 тогтоолын 10 заалт, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан үндэслэлээр 2 тогтоолын 4 заалт, шийдвэрт заасан хугацаа дууссан үндэслэлээр 3 тогтоолын 3 заалт.

Ингээд нийт Төрийн байгуулалтын байнгын хорооны 7 тогтоолын 18 заалтыг тус тус хяналтаас хасахыг Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолын 1 дүгээр хавсралтаар оруулж байна.

Тогтоолын 2 дугаар хавсралтаар 10 хуулийн 18 заалт, Улсын Их Хурлын 25 тогтоолын 67 заалт, Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 тогтоолын 57 заалтыг хяналтад хэвээр нь үлдээж байгаа гэдгийг нь гаргаж ирээд 2 дугаар хавсралтаар батлан баталгаажуулж Засгийн газарт хүргүүлэх ийм тогтоолын төслийг боловсруулж Та бүхэнд танилцуулж байна.

Үүний ач холбогдол нь өөрөө юу юм бэ гэхээр Хяналт шалгалтын тухай хуулиар Засгийн газар жилд 2 удаа биелэлтийг тайлагнадаг.

Тайлагнахдаа 5 мянга гаруй зүйл, заалт, үзүүлэлтээр тайлагналтаа ирүүлдэг.

Ингэхдээ 2017, 2018 онд өгөгдсөн үүрэг даалгавруудыг одоог хүртэл хяналтаас хасаагүй учраас тайлагнасан хэвээрээ байгаа нь ажил үүргийн чиг үүргийг маш их хүндрүүлж байгаа учраас эдгээр зүйл, заалтуудыг хасахаар оруулж байна.

Шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

“Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Дараагийн асуудалдаа оръё.

**Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын
жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх
эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв**

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Дашцэрэнгийн Энхтүвшин, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Б.Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая гэлээ. Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг нээж өгье.

Б.Пүрэвдорж: Б.Бат-Эрдэнэ нарын гишүүний өргөн барьсан Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон А.Ариунзаяа нарын гишүүдийн өргөн барьсан Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр миний кноп ажиллаагүй тул дахин санал хураалт явуулж өгнө үү? Хүчингүй болгож санал хураалт.

Б.Жавхлан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар саяын дурдсан хэлэлцэх асуудлууд дээр гаргасан санал хураалтын дүнг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалтад гишүүд бэлдэнэ үү.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналын дагуу Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаараа хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураасан өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, уг санал 59.1 хувиар дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байгаарай. Сая уншсан саналын томьёоллоор хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн.

Тэгээд бүтэн унших уу? Бүтэн уншъя. Тэгвэл.

Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 18 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь

хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, уг санал 59.1 хувиар дэмжигдлээ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор өмнө нь санал хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалтад гишүүд бэлдэх нь байна шүү. Эхлээд.

Гишүүд санал хураалтанд бэлэн болсон байна. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, уг санал 59.1 хувиар дэмжигдлээ.

Ингээд одоо дахин санал хураалт явах нь байна. Шинээр.

Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 8 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн уг саналыг дэмжиж, 59.1 хувиар уг санал дэмжигдлээ.

Аюушийн Ариунзаяа гишүүн горимын санал. Гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай буюу малчны хүүхдийг 6 настайд нь сургуульд оруулаад 1, 2 дугаар ангидаа хувилбарт сургалтад хамрагдах буюу гэрээр, зайнаас алсаас сургах боломжийг нь нээх, 8 настайд нь 3 дугаар ангиас нь танхимаар элсэн суралцах боломжийг нь нээж өгөх ийм чухал хуулийн төсөл түрүүн хэлэлцэх эсэх асуудлаас нь уналаа.

Би бас санал өгч амжаагүй байсан учраас тухайн санал хураалтыг хүчингүйд тооцож, хэлэлцэх асуудалд оруулж өгнө үү. Энэ маш чухал асуудал байгаа юм гэдгийг онцлон дурдъя. Баярлалаа.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа гишүүний горимын саналаар Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураасан өмнөх санал хураалтын дүнг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт.

Эхлээд гишүүд санал хураалтад бэлтгэнэ үү. Гишүүд санал хураалтад бэлэн боллоо. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, уг санал 54.5 хувиар дэмжигдлээ.

Одоо дахиж санал хураалт явах боллоо.

Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож. Б.Баярбаатар гишүүн горимын санал гаргая гэж байна. Б.Баярбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Баярбаатар: Саяын санал хураалт дээр техник ажилласангүй. Би бас давхар хоцрох шиг боллоо.

Тэгээд хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Дэмжиж өгнө үү?

Б.Жавхлан: Б.Баярбаатар гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалтад гишүүдэд бэлтгэнэ үү.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд танхимдаа орж ирж санал хураалтад оролцоно уу.

Д.Амарбаясгалан гишүүн, Б.Батбаатар гишүүн, Э.Болормаа гишүүн, Л.Гантөмөр гишүүн, Т.Доржханд гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ө.Шижир гишүүд танхимдаа орж ирж санал хураалтад оролцсон уу?

Санал хураалтад гишүүд бэлэн боллоо. Саяын уншсан томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт эхэлсэн шүү.

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, гишүүний гаргасан горимын санал 59.1 хувиар дэмжигдэж, өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж нарын 36 гишүүн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, уг санал 54.5 хувиар уг санал дэмжигдлээ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн горимын санал. Гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Одонгийн Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн хуулийн төслийг хэлэлцэх үед миний төхөөрөмж ажилласангүй.

Тийм учраас дахин санал хураалт явуулж өгье.

Хоёрдугаарт нь, Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга нарын гишүүдийн өргөн барьсан Банкны тухай хууль дээр бас төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалгаж өгнө үү?

Б.Жавхлан: Та хоёр асуудал дээр нэг горимын санал гаргаж болохгүй шүү дээ. Тус тусад нь гарга.

Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Одонгийн Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль дээр миний төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалгаж өгнө үү.

Хүчингүй болгох санал хураалт.

Б.Жавхлан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний горимын саналаар Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 06 сарын 05-ны

өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалгана.

Тийм учраас гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт нь бэлэн боллоо.

Саяын уншиж танилцуулсан саналын томьёоллоор. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 54.5 хувиар Б.Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар уг санал хүчингүй болж дэмжигдлээ.

Одоо дахин санал хураах нь.

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 06 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана.

Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Санал хураалтад гишүүд бэлэн болсон байна.

Сая уншиж танилцуулсан санал томьёоллоор санал хураалт. /алх цохив/

22 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн зөвшөөрч, уг санал 54.5 хувиар дэмжигдлээ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая гэсэн. Микрофоныг нь нээе.

Б.Пүрэвдорж: П.Мөнхтулга нарын гишүүдийн өргөн барьсан Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед миний төхөөрөмж ажиллаагүй тул санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулж өгнө үү.

Б.Жавхлан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга 2026 оны 05 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт

заасныг дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт хураана.

Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Гишүүд санал хураалтад бэлэн болсон байна.

Өмнөх санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор. Тийм ээ. Томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 22 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 45.5 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудлын 10, 11, 12-т байгаа Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Дашцэрэнгийн Энхтүвшин, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг нэгтгэсэн байдлаар гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг хараахан нэгтгэж дуусаагүй.

Ажлын хэсгийн явц үргэлжилж байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдааныг маргааш өглөө 09.00 цагт үргэлжлүүлэхээр түр завсарлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсэг яг одоо “Жанжин Д.Сүхбаатар” танхимдаа үргэлжилнэ. Ажлын хэсгийн гишүүдийг уг танхимд дуудна уу. Дэгийн тухай хууль.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 15 цаг 25 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД